


ХОРИХ БАЙГУУЛЛАГААС СУЛЛАГДАГСДЫГ НИЙГЭМШҮҮЛЭХЭД ШШГБ-ЫН ОРОЛЦОО, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА



Цэдэвсономын Очгэрэл

Хорих 415-р ангийн дарга, дэд хурандаа, докторант

1.Хорих байгууллага дахь нийгэм сэтгэл зүйн ажил, цаашдын чиг хандлага

Түүх судлаачдын үздэгчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс Ардын түр засгийн газрын шийдвэрээр “Гяндан салаа” нэртэйгээр байгуулагдсан байдаг. Тэр цаг үеэс өнөөдрийг хүртэл хорих ял шийтгэгдсэн хоригдогсдыг хорих орчин нөхцөл, хөдөлмөр эрхлэлт, сургалттай холбогдсон үйл ажиллагаа тухайн цаг үеийн нийгмийн тогтолцооны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй хэрэгжүүлж ирсэн. Өнөөгийн ардчилсан, чөлөөт нийгмийн тогтолцоо бүхий улс орнуудад үндсэн хууль болон олон улсын эрх зүйн бичиг баримтаар хүний эрх, эрх чөлөөг дээдлэн баталгаажуулахын зэрэгцээ нийгмийн хамгийн үнэт зүйл болох хүний хөгжлийг эрхэм зорилго болгож байгаа ба энэ нь тухайн улсын хорих байгууллагын үйл ажиллагаанд хоригдогсдыг нийгэмшүүлэх ажлыг оновчтой зөв зохион байгуулах байдлаар хэрэгжиж байна.

Хууль Зүй Дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тогтолцоонд нийгмийн ажилтан хэмээх албан тушаалтан нь нийгмийн шаардлагаар 2003 оны сүүлчээр бий болсон бөгөөд өнөөдрийн байдлаар хорих ангиудын хэмжээнд 82 нийгмийн ажилтан ажиллаж байна.

Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөхийн зэрэгцээ нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны талаар судалдаг манай эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагууд тодорхойлж байгаа члан нийгмийн ажил гэдэг нь: нийгэм болон хүмүүсийн сайн сайхны төлөө тэдгээрийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлуудыг илрүүлж шийдвэрлэхэд туслах, хүнийг чадваржуулах, хөгжүүлэх явдлыг дэмжих мэргэжлийн үйл ажиллагаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь нийгэмшүүлэх ажлыг олон улсын жишигт нийцүүлэн Монгол улсын нөхцөлд тохиромжтой байдалд хэрэгжүүлэх зорилгоор 2000 онд Хууль Зүй Дотоод хэргийн сайдын тушаалаар “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр”, 2010 онд “Хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн үйл ажиллагааны заавар”-ыг батлан гаргасан бөгөөд одоо эдгээр бичиг баримтыг хэрэгжүүлэхээр идэвхийлэн ажиллаж байна.



Хорих байгууллагын нийгмийн ажил буюу хоригдогсдод нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг дараах хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Үүнд:

- 1.Хоригдогсдыг бүхий л талаас нь судлан, холбоо тогтоох
- 2.Хорих ял эдлэх, хоригдох явцад тулгарч буй ахуйн орчны болон бусад бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, яриа таниулга хийх
- 3.Хоригдогсдын хувийн нөөц боломжийг илрүүлэх, тэдгээрийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалтуудыг зохион байгуулах
- 4.Хоригдогсдын сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх, нөлөөллийн үйл ажиллагааг дотоод болон бусад албад, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх.
- 5.Хоригдогсдын хуулиар хориглоогүй эрхийг хангах, түүнийг гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх
- 6.Хоригдогсдыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх

2.Хоригдогчдыг суллагдан гарахад бэлтгэх үйл ажиллагаа

Хорих байгууллагын нийгмийн ажлын онцлог чухал хэсэг нь хоригдогсдыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэл үйл ажиллагаа юм.

Ялын хугацаа дууссан болон тэнсэн суллагдах нөхцлийг хангасан хоригдогсдыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:


- 1.Нийгмийн амьдралд гарах буюу бие дааж нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах бүхий л төрлийн мэдээллээр хангах
- 2.Үүсэн гарах бэрхшээлийг хэрхэн давах, гэр бүл орчинтойгоо хэрхэн харьцах талаар зөвлөгөө өгөх
- 3.Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран бичиг баримтжуулах, ажлын байр олгоход холбон зуучлах.
- 4.Суллагдахаас 6 сарын өмнө судалгаанд авч, нийгэмд гарахад нь бэлтгэх төлөвлөгөө гарган мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулах

3. Суллагдагсдыг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулалтын ажилд оруулах санал /түүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоо/

Хорих ангиас суллагдсан хүмүүсийн зүгээс дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй суллагдсаны дараа нийгэмд байр сууриа олж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.


2010 оны эцэст хорих ял эдэлж байсан 5700 ялтнаас анх удаагийн шийтгэлтэй 2751, дахин давтан шийтгүүлсэн 2949 байна.

Дахин давтан шийтгүүлсэн байдал




Нас	Тоо
18-34 настай	3178
35-54 настай	2382
55-69 настай	117

2011 онд суллагадх ялтны урьдчилсан судалгааг авч үзвэл:





Боловсрол :



Мэргэжил:



Ялтны дунд явуулсан судалгаанаас /ярилцлагын чиглэлээр/ үзэхэд дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй дараах шалтгаан нөхцлөөс дурьдвал:

1. Хүлээж авах орчин байхгүй.

- Очих газаргүй, орон гэргүй, төрөл садангүй

2. Амьдралын буюу амьжиргааны эх үүсвэр байхгүй

- Ар гэр нь өрхийн орлогогүй, хөрөнгийн чадваргүй

3. Суллагдаж буй хүмүүсийн хувийн онцлогтой холбогдолтой шалтгаан:

- Иргэний бичиг баримтгүй

- Боловсролгүй, мэргэжилгүй

- Амьдралын зорилгогүй, идэвхгүй, этгээд гаж сонирхолтой, донтой



4. Нийгмийн болон эдийн засгийн тогтолцоотой холбоотой шалтгаан:

- Ажилгүйдэл,
- Ядуурал
- Улс төр, эдийн засгийн хямрал гэх мэт.

Хорих ял шийтгэгдсэдийг суллагдахад бэлтгэх, хүлээж авах нийгэм эрх зүйн орчныг бүрдүүлэх, улмаар нийгмийн идэвхтэй зөв гишүүн болгон төлөвшүүлэх нь тэдгээрийг дахин гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ хувийн болон гэр бүлийн цаашилбал нийгмийн хөгжилд үр дүнгээ өгөх ажил болох нь гарцаагүй юм.

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан, хугацаа дуусч суллагдсан, хорих ялыг хойшлуулсан, тэнсэн харгалзсан хүмүүстэй хэрхэн ажиллах, тэдгээртэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх зарчмаар дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх саналтай байна.

а.Хорих анги дахь хоригдогсдыг нийгэмшүүлэх суллагдахад бэлтгэх ажлыг мэргэжлийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах.

б.Суллагдахын өмнө буюу дараа амьдрах ухааны болон мэргэжлийн сургалтад хамруулж бие дааж амьдрах чадвар эзэмшүүлэхэд анхаарах.

в.Суллагдсан хүмүүсийг хүлээн авахад төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хамгаас чухал гэж үзэж байна.

Мөн гэмт хэрэгт холбогдон улмаар хорих ял эдэлсэн хүмүүсийг төлөвшүүлж хөгжүүлэхэд чиглэсэн ажил нийгэмд асар чухал ач холбогдолтой арга хэмжээ гэдгийг төрийн болон төрийн бус байгууллагууд бүхий л түвшинд дэмжих явдал чухлаар тавигдаж байна.

Суллагдагсдыг нийгэмшүүлэх тогтолцоог бүрдүүлснээр хүрэх үр дүн, нийгэм эдийн засгийн ач холбогдол талаас нь дурдвал:

- Нийгмийн харилцааг хамгаалах нөхцөл зарим талаас нь бүрдэнэ.
- Давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурна.
- Нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах бүтээн байгуулагч иргэн төлөвшинө.

Нийгмийн ухамсар



Нийгмийн соёл

Нийгмийн төлөвшил



Нийгмийн ухамсар, соёл, төлөвшилд сөргөөр нөлөөлж буй шалтгааныг олж илрүүлэн арилгах боломж бүрдэнэ.

Суллагдсан хүнийг хүлээн авахад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог дараах байдлаар тодорхойлж болох юм.

1. ШШГБ-нь хоригдогчийг нийгэмшүүлэх нийгэмд гарахад нь бэлтгэх

Хорих ял эдэлж байх хугацаанд шоронжиж байна гэж үзвэл үүнийг таслан зогсоох чиглэлээр:

- Стандартыг хянах /орчны/
- Нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
- АБХ-ийн асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэх
- Бусад буюу мэдээлэл өгөх

2. Цагдаагийн байгууллага нь суллагдсдад хууль зүйн талаас нийгмийн харилцаанд ороход зөвөлгөө өгөх гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх

3. Иргэний бүртгэлийн байгууллага :

Суллагадхын өмнө буюу дараа бичиг баримтжуулах шаардлагатай лавлагааг гаргаж өгөх

4. Орон нутгийн засаг захиргааны байгууллага :

- Харьяа иргэдийн дунд судалгааны хүрээнд хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргаж төрсний гэрчилгээ, бусад шаардлагатай бичиг баримтаар хангах

- Ар гэрт нь хандсан нийгмийн ажлын үйлчилгээг зохион байгуулах

- Сум хорооны нийгмийн ажилтан суллагдсдыг хүлээн авах, хорооны байцаагч, нийгмийн ажилтан нартайгаа холбоотой ажиллах, тэднийг ажилд зуучлах

- Тухайн орон нутагт оршин буй хорих байгууллагын үйл ажиллагаа хоригдогчийн нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх зэрэгт хамтран ажиллах

- Суллагдсан хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн халамжийн болон хөдөлмөрийн газрууд олон нийтийн байгууллагууд бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг маш чухал үүрэгтэй оролцох.

5. Төрийн бус байгууллагууд: Дээрхи үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллах

6. Нийгмийн халамжийн болон хөдөлмөрийн байгууллагууд: Суллагдсан хүмүүст мэргэжлийн боловсрол олгох ажлын байраар хангахад зуучлан дэмжих, орон байр болон бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжиж оролцох.

Эндээс дүгнэхэд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх зорилгоор дээрхи төрийн болон төрийн бус байгууллага нь хамтын ажиллагааны гэрээ байгуулах эсхүл хамтарсан ажлын зөвлөл, баг байгуулан ажиллах замаар нягт хамтарч ажиллах тодорхой тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгож ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Хорих байгууллага суллагдсдын дундаас тодорхой хэсгийг буюу оршин суух



хаяггүй, амьжиргааны эх үүсвэргүй, төрөл садан, ар гэргүй, хүмүүсийг хүлээн авах төв бий болгох. Энэ төвийн санхүүжилтийг төсвөөс болон хандив тусламжийн эх үүсвэрээс шийдвэрлэх ба хэрэгжүүлэх байгууллагаар энэ чиглэлд ажиллаж чадах төрийн бус байгууллагыг ажиллуулах.

Суллагдагсдыг хүлээн авах төв нь:

- Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх
- Мэргэжлийн сургалтын холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Ажлын байранд зуучилж өгөх,
- Бичиг баримтжуулах орон гэртэй болгох бусад бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэж өгөхөд туслах,
- Цагдаагийн байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийх зэрэг үйл ажиллагаа хийдэг байвал зохино.
- Үйл ажиллагааны зохион байгуулалт санхүүгийн, харилцаа зэргийг судалгаа явуулж хэлэлцэн шийдвэрлэх
- Ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллагуудад тавигдах шаардлагад хорих байгууллагаас суллагдагсдыг ажлын байраар ханган ажиллуулах талаар шийдвэрлэх,
- Хувь хүнийг ажилд ороход болон бусад бүхий л тохиолдолд материал бүрдүүлэхэд урьдах ял шийтгэлийн нарийвчилсан тодорхойлолтыг бус сум, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчийн тухайн хувь хүний сэтгэл зүй, цаашдын хөдөлмөрийн чадварын түвшинг тогтоосон тодорхойлолтыг үндэслэн авдаг тогтолцоог бий болгох,
- Нийгмийн ухамсарт нөлөөлөх зорилгоор суллагдагсдыг нийгэмшүүлэх орчинг бүрдүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах,
- Дээрх ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор санал бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох: